

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/49/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545

цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт.....	
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17
Товчилсон үгийн жагсаалт	
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭЭС	Эмийн эргэлтийн сан



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагараа баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.25 № 2/58
танай _____-ны № _____-т

ДӨРГӨН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ ЭМЧ М.ХӨХНОХОЙ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Авлага, бараа материал, орлого үр дүнгийн тайланд орлого дутуу тусгасан, тайлант үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй, эмийн орлого зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, тайлант оны эцэст тооллого хийж тооцоо бодож баталгаажуулаагүй, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, бараа материалын худалдан авалтыг төлбөрийн баримтгүйгээр ажил гүйлгээг гаргасан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Татварын ерөнхий хуулийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа" 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Үнэн зөв байх", "Иж бүрэн байх", "Тохиолдсон байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

021000404

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43,484,167.08</u>	<u>81,257,343.40</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,966,643
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,966,643
3121	Төгрөг	-	2,966,643
31211	Төрийн сангийн харилцах	-	2,966,643
33	АВЛАГА	2,301,351.58	28,637,051.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	9,605.58	1,326,340.55
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	25,961,500
335	Бусад авлага	1,700,346	1,349,211
3351	Байгууллагаас авах авлага	999,346	649,211
3352	Хувь хүмүүсээс авах авлага	701,000	700,000
34	УРЬДЧИЛГАА	-	100,000
3471	Урьдчилгаа тооцоо	-	100,000
34713	Цалингийн урьдчилгаа	-	100,000
35	БАРАА МАТЕРИАЛ	41,182,815.50	49,553,648.85
351	Түүхий эд материал	9,150,026.50	11,234,291.45
35130	Эм боох материал	9,150,026.50	11,234,291.45
354	Хангамжийн материал	32,032,789	38,319,357.40
35410	Бичиг хэргийн материал	34,650	154,500
35420	Аж ахуйн материал	31,314,839	37,415,157.40
35460	Хүнсний материал	483,300	749,700
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>341,071,952.63</u>	<u>328,136,540.23</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	341,071,952.63	328,136,540.23
392	Биет хөрөнгө	324,963,702.67	312,119,690.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	259,032,109.06	259,032,109.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	(21,578,671.32)	(32,725,352.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,214,222.00	40,214,222.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22,475,841.15)	(28,579,110.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	154,527,420.00	175,446,627.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(91,439,505.88)	(107,239,224.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,568,132	18,568,132
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,928,162.04)	(12,847,212.08)
39217	Ном	44,000	249,500
393	Биет бус хөрөнгө	16,108,250	16,016,850
39301	Програм хангамж	732,000	732,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(457,800.04)	(549,200.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,834,050	15,834,050
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>384,556,119.71</u>	<u>409,393,883.63</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,232,919.80</u>	<u>4,190,130.05</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,232,919.80	4,190,130.05

413	Өглөг	2,232,919.80	4,190,130.05
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	382,938	126,306
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,849,981.80	2,555,928.05
4136	Бусад өглөг	-	1,507,896
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,071,000
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	436,896
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	382,323,199.91	405,203,753.58
51	Засгийн газрын хувь оролцоо	382,323,199.91	405,203,753.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	191,439,640	191,439,640
51101	Өмч: - төрийн	191,439,640	191,439,640
512	Хуримтлагдсан үр дүн	(87,185,142.15)	(64,304,588.48)
51210	Өмнөх үеийн үр дүн	(87,185,142.15)	(87,185,142.15)
51220	Тайлант үеийн үр дүн	-	22,880,553.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	278,068,702.06	278,068,702.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	384,556,119.71	409,393,883.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	449,121,804	590,152,428.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,225,189	32,902,313.46
120	Нийтлэг татварын бус орлого	57,225,189	32,902,313.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,225,189	32,902,313.46
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	57,225,189	32,902,313.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	391,896,615	557,250,115
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	339,952,100	393,538,042
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	21,615,842
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	339,952,100	371,922,200
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,802,875	31,433,223
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,802,875	30,830,723
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	602,500
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,172,100	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,172,100	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,969,540	132,278,850.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,969,540	132,278,850.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	414,143,497.72	567,271,874.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	414,143,497.72	567,271,874.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	413,210,877.72	537,671,874.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,009,561	310,532,056
210101	Үндсэн цалин	181,238,134	310,532,056
210102	Нэмэгдэл	51,726,064	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,769,000	-

210104	Урамшуулал	20,276,363	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,592,482.42	39,705,647.03
210201	Тэтгэврийн даатгал	23,631,812.72	27,289,824.79
210202	Тэтгэмжийн даатгал	2,580,095.61	3,105,320.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,064,076.49	2,484,256.45
210204	Ажилгүйдлийн даатгал	481,063.42	615,604.11
210205	Эрүүл мэндийн даатгал	4,835,434.18	6,210,641.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,171,323	20,330,442
210301	Гэрэл, цахилгаан	1,968,653	1,582,242
210302	Түлш, халаалт	20,202,670	18,748,200
2104	Хангамж, бараа материалын зардал	25,347,010	34,538,900
210401	Бичиг хэрэг	3,137,450	3,071,350
210402	Тээвэр, шатахуун	16,760,660	25,288,900
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,967,500	2,491,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,400	3,396,150
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	981,000	291,500
2105	Нормативт зардал	40,883,367	88,347,571.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,959,107	76,611,682.80
210502	Хоол, хүнс	7,239,760	10,556,550
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	684,500	1,179,339
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	450,000	-
210604	Урсгал засвар	450,000	-
2107	Томилолт, зочны зардал	350,000	237,000
210702	Дотоод албан томилолт	350,000	237,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,757,818.30	1,343,750
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,137,818.30	288,750
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	200,000
210803	Даатгалын үйлчилгээ	131,000	300,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,000	25,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	80,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	165,000	450,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,649,316	42,636,507.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,029,650	8,576,388
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,619,666	34,060,119.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	932,620	29,600,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,000	29,600,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,000	29,600,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	862,620	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	862,620	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>34,978,306.28</u>	<u>22,880,553.67</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>34,978,306.28</u>	<u>22,880,553.67</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(87,185,142.15)	382,323,199.91
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(87,185,142.15)	382,323,199.91
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(87,185,142.15)	382,323,199.91
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(87,185,142.15)	382,323,199.91
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(87,185,142.15)	382,323,199.91
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	22,880,553.67	22,880,553.67
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(64,304,588.48)	405,203,753.58

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	391,896,615	531,880,015
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	591,400
120	Нийтлэг татварын бус орлого	-	591,400
120009	Бусад орлого	-	591,400
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	391,896,615	531,288,615
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	339,952,100	393,538,042
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	21,615,842
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	339,952,100	371,922,200
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,802,875	31,433,223
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,802,875	30,830,723
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	602,500
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,172,100	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,172,100	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,969,540	106,317,350
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,969,540	106,317,350
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	391,896,615	528,913,372
21	УРСГАЛ ЗАРДАЛ	391,896,615	528,913,372
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,372,595	499,313,372

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,521,317	308,863,936
210101	Үндсэн цалин	167,286,746	187,359,358
210102	Нэмэгдэл	68,171,000	94,333,778
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,100,211	5,292,000
210104	Урамшуулал	14,963,360	21,878,800
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,044,200	42,602,032
210201	Тэтгэврийн даатгал	24,255,300	30,851,632
210202	Тэтгэмжийн даатгал	2,595,900	2,937,600
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,076,700	2,350,100
210204	Ажилгүйдлийн даатгал	924,600	587,500
210205	Эрүүл мэндийн даатгал	5,191,700	5,875,200
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,195,323	20,876,842
210301	Гэрэл, цахилгаан	1,968,653	1,682,242
210302	Түлш, халаалт	19,026,670	18,748,200
210303	Цэвэр, бохир ус	200,000	446,400
2104	Хангамж, бараа материалын зардал	25,658,200	31,109,059
210401	Бичиг хэрэг	3,524,200	1,912,650
210402	Тээвэр, шатахуун	17,475,800	24,133,171
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,222,500	2,563,238
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,435,700	2,500,000
2105	Нормативт зардал	37,882,889	83,680,318
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,419,659	71,399,418
210502	Хоол, хүнс	7,505,730	9,495,500
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,957,500	2,785,400
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,374,500	1,939,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,627,200	1,000,000
210604	Урсгал засвар	747,300	939,000
2107	Томилолт, зочны зардал	545,200	237,000
210702	Дотоод албан томилолт	545,200	237,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,603,866	1,105,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,663,366	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	200,000
210803	Даатгалын үйлчилгээ	300,000	300,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000	25,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,000	80,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	335,500	500,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,547,100	8,900,185
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,547,100	8,900,185
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,524,020	29,600,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,000	29,600,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,000	29,600,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,454,020	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,454,020	-

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	<u>2,966,643</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	2,966,643
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,966,643

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	383,682,500	379,231,120	418,536,100	409,840,249
21	УРСГАЛ ЗАРДАЛ	383,682,500	379,231,120	418,536,100	409,840,249
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,182,500	379,231,120	418,336,100	409,640,249
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,573,700	255,521,317	293,761,400	285,746,969
210101	Үндсэн цалин	168,974,200	167,286,746	182,323,200	174,938,105
210102	Нэмэгдэл	66,158,100	68,171,000	84,267,400	83,638,064
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000	5,100,211	5,292,000	5,292,000
210104	Урамшуулал	16,897,400	14,963,360	21,878,800	21,878,800
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,772,500	35,044,200	39,657,800	39,657,800
210201	Тэтгэврийн даатгал	24,469,600	24,255,300	27,907,400	27,907,400
210202	Тэтгэмжийн даатгал	2,575,700	2,595,900	2,937,600	2,937,600
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,060,600	2,076,700	2,350,100	2,350,100
210204	Ажилгүйдлийн даатгал	515,100	924,600	587,500	587,500
210205	Эрүүл мэндийн даатгал	5,151,500	5,191,700	5,875,200	5,875,200
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,219,500	21,195,323	21,245,800	20,676,842
210301	Гэрэл, цахилгаан	2,051,200	1,968,653	2,051,200	1,482,242
210302	Түлш, халаалт	18,621,900	19,026,670	18,748,200	18,748,200
210303	Цэвэр, бохир ус	546,400	200,000	446,400	446,400
2104	Хангамж, бараа материалын зардал	25,242,400	25,658,200	24,350,000	24,335,888
210401	Бичиг хэрэг	2,300,000	3,524,200	1,000,000	1,062,650
210402	Тээвэр, шатахуун	18,202,400	17,475,800	18,210,000	18,210,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,240,000	2,222,500	2,640,000	2,563,238
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000	2,435,700	2,500,000	2,500,000
2105	Нормативт зардал	25,976,000	26,671,414	31,526,500	31,504,400
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,518,500	16,208,184	21,063,500	21,063,500
210502	Хоол, хүнс	7,500,000	7,505,730	7,663,000	7,655,500
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,957,500	2,957,500	2,800,000	2,785,400
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,579,800	3,374,500	1,952,600	1,939,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,627,200	2,627,200	1,000,000	1,000,000
210604	Урсгал засвар	952,600	747,300	952,600	939,000
2107	Томилолт, зочны зардал	722,800	545,200	237,000	237,000
210702	Дотоод албан томилолт	722,800	545,200	237,000	237,000

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,305,000	6,673,866	1,105,000	1,105,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,200,000	5,663,366		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	270,000	200,000	200,000
210803	Даатгалын үйлчилгээ	300,000	300,000	300,000	300,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000	80,000	25,000	25,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,000	25,000	80,000	80,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000	335,500	500,000	500,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,790,800	4,547,100	4,500,000	4,437,350
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,790,800	4,547,100	4,500,000	4,437,350
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000	-	200,000	200,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000	-	200,000	200,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000	-	200,000	200,000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	383,682,500	379,231,120	418,536,100	412,806,892
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	339,952,100	339,089,480	371,922,200	393,538,042
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	339,952,100	339,089,480	371,922,200	371,922,200
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,172,100	22,172,100	22,198,400	21,615,842
132001	Орон нутгийн төсвөөс	22,172,100	22,172,100	22,198,400	21,615,842
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,558,300	17,969,540	24,415,500	19,268,850
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,558,300	17,969,540	24,415,500	19,268,850
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				2,966,643
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22	22	22
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	16	16
620003	Үйлчлэх ажилтан	4	4	4	4
620004	Гэрээт ажилтан	1	1	1	1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22	22	22	22
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	16	16	16	16
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	5	5
650010	Гэрээт ажилтан	1	1	1	1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,802,875	119,073,123
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,802,875	119,073,123
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,211,475	89,673,123
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	23,116,967
210101	Үндсэн цалин	-	12,421,253
210102	Нэмэгдэл	-	10,695,714
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,944,232
210201	Тэтгэврийн даатгал	-	2,944,232
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	200,000
210301	Гэрэл, цахилгаан	-	200,000
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,773,171
210401	Бичиг хэрэг	-	850,000
210402	Тээвэр, шатахуун	-	5,923,171
2105	Нормативт зардал	11,211,475	52,175,918
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,211,475	50,335,918
210502	Хоол, хүнс	-	1,840,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,462,835
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,462,835
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	29,400,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	29,400,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	29,400,000
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	591,400	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	591,400	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,802,875	119,073,123
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,802,875	119,073,123
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	87,048,500
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,802,875	31,422,123
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	602,500

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дөргөн сумын ЭМТөв нь “Үйлчлүүлэгчийн эрх, хэрэгцээг хангасан тусламж үйлчилгээ үзүүлэх” гэсэн зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- *Сумын иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг шуурхай, чанартай үзүүлэх,*
- *Нийгмийн эрүүл мэндийн туламж үйлчилгээ үзүүлэх, иргэдэд Эрүүл мэндийн боловсрол олгох,*
- *Үйлчлүүлэгчдэд тав тухтай орчин бий болгох,*
- *Лабораторийн тусламж үйлчилгээ*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас тус байгууллагын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 531.9 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 7.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5.9 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.7 сая төгрөгөөр буюу 6.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өглөгийн данс байна.

Тайлант оны эхэнд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байсан ба оны эцэст 2.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны оны эхний үлдэгдэл 2.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 28.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 26.3 сая төгрөгөөр өссөн байна. Эцсийн авлагын нийт үлдэгдэл 25.9 сая төгрөг нь ЭМД-ын сангаас ковид-19 санхүүжилт, 1.3 сая төгрөг нь ажиллагчидтай холбогдсон авлага, 1.3 сая төгрөг нь цалингийн урьдчилгаа бодон бусад тооцооны авлага байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 119.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 15.4 сая төгрөгөөр нийт 134.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 126.1 сая төгрөгийн материалыг зарцуулж оны эцэст 49.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 488.9 сая төгрөг байсан бол оны эцэст 510.1 сая төгрөг болж 21.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр хөрөнгө худалдан авсан, үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант онд 3.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 17.5 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, тайлант онд хөрөнгө акталж устгаагүй, тайлант оны эцэст 328.1 сая төгрөгийн цэвэр үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны эцэст 4.2 сая төгрөгийн өр төлбөртэй байгаагаас Алтай сумын ЭМТ-д 1.1, эмийн өр 2.6, ажиллагсадтай холбоотой 0.5 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 382.3 сая төгрөг байсан оны эцэст 405.2 сая төгрөг болж тайлант онд 22.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 440.2 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дөргөн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 447.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 447.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Ховд аймгийн ТЕЗ-аас тус байгууллагын төсвийг 418.5 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 418.5 сая төгрөгийн төсөв баталснаас 371.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 22.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, ЭМДС-аас 24.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 371.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 21.6 сая төгрөг, ЭМДС-аас 19.3 сая төгрөг нийт 412.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 409.8 сая төгрөгийг зарцуулж 3.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 409.8 сая төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, байр ашиглалттай холбоотой тогтмол, нормативт зардлыг 8.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар ЭМДС-аас 87.0, ковидын томилолт, вакцины илүү цагийн зардалд 3.5, нэг удаагийн тэтгэмж 27.0, өмнөх оны татан төвлөрүүлэлтээс 0.6, сорьц тээвэрт 0.4, шинжилгээний орлого 0.6 сая 119.1 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 147 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн ч дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг PDF хэлбэрээр оруулаагүй, хагас жилийн санхүүгийн тайлан мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын мэдээллийг бүрэн бус мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 52.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5.2 сая төгрөгийн залруулга, 26.9 сая төгрөгийн албан шаардлага, 20.0 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт 50 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар албан шаардлагын биелэлтийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 85.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 23.9 сая төгрөгийн алдааг залруулж, 1.1 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 2.9 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 57.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Орлого үр дүнгийн тайланд үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бараа материал дутуу бүртгэсэн, мөнгөн гүйлгээний журналд орлогыг 9.7 сая төгрөгөөр дутуу,
2. Авлага 1.2, бараа материал 1.2, өглөг 5.9 сая төгрөгөөр тус тус дутуу,
3. Тайлант үеийн үр дүнг 5.9 сая төгрөгөөр зөрүүтэй,

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 23.9 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 02 дүгээр сарын 25-ны 13 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Эмч мэргэжилтэнд ажиллаагүй хоногт ур чадварын нэмэгдэл, тушаалд заагдаагүй түр гэрээгээр ажилласан ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт, дуудлага ирснийг нотлох анхан шатны баримтгүй дуудлагад шатахуунд нийт 0.6 сая төгрөгийг оны олгосон зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн: Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

4.2.2 Ажилчдад олгосон илүү цагийн хөлснөөс 0.4 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийг илүү суутгасан дутагдал илэрлээ.

Шийдвэрлэсэн: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй тул буцаан олгох төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Эмийн зардлын тооцоо бодолт хангалтгүй жилийн эцэст тооллого хийгээгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо нийлээгүй, ЭЭС-ийн эм зүйчтэй гэрээ

байгуулан тайлант онд 2.9 сая төгрөгийн цалин олгогдсон, жилийн эцэст тендерийн эмийн тооллого хийлгэдэггүй, хугацаа дууссан эм, эм эмнэлгийн хэрэгсэлд хяналт хэрэгжүүлээгүй, өмнөх СТА-аар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй дутагдал илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д " төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2- д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа" 70.2..2-т " түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/", МУЕА-ын А/95 дугаар тушаалын " албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй тул албан шаардлага өгөв

4.4 Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 52.8 сая төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн материал болон шатахуун материал худалдан авахдаа бараа бүтээгдэхүүнүүдэд гарсан зардлуудыг баримтжуулахдаа е баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг е баримтаар баталгаажуулан ажиллах.

4.3.2 Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй зөвхөн бичиг хэргийн материал худалдан авсан ямар сургалт зохион байгуулах төлөвлөгөөгүй хэчнээн хүн хамрагдсан нь тодорхой бус, нотлох анхан шатны баримтгүй байгаа нь Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолоор " Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төлөвлөгөө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг мөрдөөгүй зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, журамд заасны дагуу нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрт зарцуулах хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх, сургалтын чанарыг сайжруулан ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дөргөн сумын Эрүүл мэндийн төв	9	85.2	4	23.9	2	1.1	1	2.9	2	57.3

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

АХЛАХ АУДИТОР:

Д.НАРАНТУУЛ